

## МОНГОЛ, СОЛОНГОСЫН СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

**Т.НАМЖИЛ**

Эрт, дундал зууны үеийн Монгол, Солонгосын харилцааг судалсан эрдэмтэд цөөнгүй бий болжээ. Тухайлбал, Монголын эрдэмтдээс академич Ч.Далай, доктор Б.Сумьяабаатар, Б.Лхагваа, Ц.Шагдарсүрэн, Д.Баяр болон Лха.Дарьсүрэн, Солонгосын эрдэмтдээс Ким Сан Чи, Сан Бо Ки, Ким Ки Сонь, Чу Чхэ Хэк, Шинь Сан Гюнь нарын зэрэг олон эрдэмтдийг дурьдаж болно. Эдгээр эрдэмтдийн зарим нь шинэ чулуун зэвсгийн үед буюу Урал-алтайн хэлэнд Монгол, Солонгос ард түмэн багтан хөршлөн байсан нь гарцаагүй юм гэж үзлэг байна. Эрдэмтдийн судалгаа, бүтээлүүд нь Монгол, Солонгосын талаарх судлалыг өргөтгөж өгч байгаа юм.

Солонгосын судлаачдын үзэж байгаагаар солонгос үндэстэн 5000-аад жилийн түүхтэй аж. Кижя Чосен, Выман Чосен нь Монголын эртний өвөг улс болох Дунху хийгээд Хүннүгэй хэлхээ холбоотой байсан тухай эрдэмтэд, мэргэд түүх сударт дурьдсан байдгийг тэмдэглэжээ.

Судалгаанаас үзвэл Монголчууд нүүдлийн, Солонгосчууд нь суурин соёл иргэншилтэй. Гэсэн хэдий ч энэ хоёр ард түмэн Азийн бусад үндэстэн дотроос өөр хоорондоо зан заншлаар ихээхэн ойр төстэй байгаа нь сонирхолтой байдаг.

- Монголчууд Их гэрээс Бага гэр бүлийг бий болгож ирсэн уламжлалтай. Солонгосын Когурйө нар хүүхний эцэг эх, их гэрийн ард хүргэн болох хархүүдээ бага гэр барьж өглөг байжээ.

- Монгол, Солонгост овог төрлийг эрэгтэйн талыг баримталж иржээ.

Овгууд нэг нутгийнхан дотроо гэр бүл болохыг ихэд цээрлэдэг заншилтай.

Монгол: "Ураг төрлийн хол нь  
Ус нутгийн ойр нь дээр",

Солонгос: "Холын төрлөөс  
Ойрын айл дээр" гэдэг.

- Гэр бүл, хүний амьдралын үндсэн шаардлагаас тухайлбал, өв хөрөнгө, нутаг ус, гал голомтоо өвлөх, ахан дүүс нэг нь

\*Т.Намжил - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D)

нөгөөгөө өргөн хүндэтгэх, харилцан туслалцах, аж ахуй эрхлэлтэй нягт уялдаатайгаар Монгол ба Солонгост Азийн бусад орны адилаар Угийн бичиг үүсчээ.

Монгол, Солонгост Ургийн холбоог харуулсан Угийн /гэрийн/ бичгийг тэмдэглэдэг арга нь адил байдаг байна. Тухайлбал Монгол, Солонгост эхнэр /эх/ хүнийг дугуй дүрсээр адил тэмдэглэдэг. Угийн үеийг монгол, солонгост өөрийн, өмнөх, биеийн хойтох гэж “гурван үе”-д хуваадаг. Монголчуудтай адил Солонгост үе залгамжлах хүү төрснөөр дараагийн үе эхэлдэг уламжлалтай.

· Монголд ахынх нь зэрэгцээ отгон хүүгээ, Солонгос, Японд дүүгийнх нь зэрэгцээ ууган хүүгээ илүүтэй хүндэлдэг. Энэ бол гал голомт залгамжлах, өв хөрөнгө өвлөх ёстой холбоотой.

Монгол, Солонгост : “Эзэн нь юмаа мэддэг”, “Эзэн нь эдээ” гэсэн үг байдаг нь учиртай.

Солонгос угийн бичгийг агуулга, хүрээнийх нь хувьд хоёр төрөлд хуваан үзэж болно.

· Тэмдэглэж эхэлсэн үеэс одоог хүртэлх бүх үеийнхнийг тэмдэглэсэн угийн бичиг. Жишээ нь: Ким, Мүк гэх мэт нэгэн овогт багтах бүх хүнийг оролцуулан бичсэн. Үүнийг “Их угийн бичиг” гэдэг.

· Айл бүр “Бага угийн бичиг” гэдгийг хөтөлдөг. Энэ нь долоон үеэс эхлүүлэн хөтөлдөг байна.

Угийн бичгийг тухайн өрх гэртээ ахмад, мэддэг хүн нь хөтөлж үр хүүхэдлээ зааж өгдөг заншилтай.

· Хүйгүй айлд хүү төрөхөд охины нэр өгөх явдал Монголын адил Солонгост түгээмэл байжээ.

· Солонгосчуудын нэг онцлог нь хэл яриандаа ихээр хүндлэн өргөж байгаагаа харуулдаг. Солонгос хэлэнд найз нөхөд, дүүтэйгээ ярих хэлбэр, эцэг эх, ахмад настантайгаа, дарга, удирдах хүнтэй ярих хэлбэр гэж тусдаа байдаг байна. Тухайн хүн өөрийнхөө тухай найз нөхөдлөө ярихдаа өөрийгөө “на”, өөрөөсөө ахмад хүмүүст “цо” гэж ярьдаг. Энэ нь хүнийг маш ихэд хүндэлж байна гэсэн үг юм.

Ахмад хүмүүсээ “Даншин” гэж хүндэлж ярина.

Хооллохдоо дүү хүн нь нас ахмад хүнээсээ түрүүлж хоол, ундандаа хүрдэггүй.

· Өвөө, аавыгаа 60 настай залгахад нь бүх хамаатан садан, танилууд, хөрш зэргэлдээх айлын хүмүүсээ урьж хүндэтгэлийн том найр хийдэг заншилтай.

· Монголчуудын адил Солонгосчууд ахмад хүнд юм өгөх, авахдаа нэг гараараа өгч авдаггүй, хоёр гараараа өргөн барьдаг, авдаг. Эсвэл нэг гараараа нөгөөг нь түшин өгч, авна.

Ахмад хүний өмнө өвдөг дээрээ сөхрөн суугаад бөхийн мэндэлдэг. Энэ нь их хүндэтгэл болдог аж.

Солонгосчуудын өөр нэг онцлог тал нь нас ахмад хүнтэй мэндлэхдээ аяархан дуугаран, толгой бөхийн, харцаа дойшлуулан нуруугаараа хотойн мэндэлдэг. Тухайн хүнийг хэр зэрэг хүндэлж байгаагаас шалтгаалан улам их бөхийдөг байна.

Эмэгтэй, дүү хүмүүс настай хүний өмнө томоор инээх, чангаар ярих, хүүхдээ зэмлэн загнах зэргийг цээрлэдэг байна.

Өвөө, эмээ, хадам эцэг, эхийнхээ дэргэд биеэ хянасан, хүндэтгэлтэй байдлыг үзүүлж байх ёстой аж.

Монгол, Солонгосын гэр бүлийн зан заншлын тухайлбал хүмүүсийн оюун санааны хүрээнд дараах нийтлэг талууд байна гэж үзэж болох юм.

- Гэр бүлийн зан заншлын уламжлалын хувьд өрнө, дорно дахины орнуудаас Монгол, Солонгосын ард түмнүүд хоорондоо илүү төстэй байдгийн нэг суурь нь Их гэр бүл бололтой.

- Овогоо, эцэг өвгөдөө эрхэмлэсээр удам угсаагаа хадгалж, Угийн бичиг Гэрийн бичиг хөтөлж, тэр нь өвлөгдсөөр ирсэн.

Солонгосчуудын Угийн бичгийн тэмдэглэгээ эрт үеийн байдлыг илүү хадгалсан байдалтай.

- Ураг төрөл, угийн бичгээ үеэс үед сайн мэдэхийг эрмэлздэг.

- Гэр бүлийн уламжлалд зан заншлын тухайлбал аман зохиолын төрөл, хэлбэрүүд нэгэн гол байрыг эзэлсээр иржээ.

Монгол, Солонгосын түүх, уламжлалын үүсэл, арга хэлбэр, тэдгээрийн нийтлэг тал, онцлогийг сэргээн судлах нь эдгээр орны ард түмний гарваль хамаадал, соёл, мэдлэг, харилцан холбоо, нөлөөг тодруулахад багагүй ач холбогдолтой юм.

Монгол ба Солонгосын ард түмний харилцаа бие биедээ харилцан нягт нөлөөлсөн, гүн гүнзгий уламжлалтай явж ирэхэд нь Азийн бусад үндэстнээс илүү адил төстэйн нэг гол суурь дэвсгэр нь оюун санааны амьдралын, түүний үзэл санааны уламжлалтай холбоотой гэж үзэж байна.